



Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар

“Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан /ГАГ-ДУА-2018-01-ГА /



*Орон нутгийн
төсвийн хөрөнгө
оруулалт үр дүн
муутай байна*



Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгс	3
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4-6
Дарга, тэргүүлэх аудитор П.Төвсанаа	Бүлэг 1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөхгүй байна.	7-8
Аудитын менежер Х.Наранцацрал	1.1 <i>Зарим төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Засаг даргын мөрийн хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулаагүй байна.</i>	7
Ахлах аудитор Ч.Бэрхсайхан	1.2 <i>Шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг баталсан байна.</i>	8
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70593208 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.	Бүлэг 2. Бараа, ажил, үйлчилгээ гэрээний хугацаанд багтаж хэрэгжсэн боловч зарим худалдан авах ажилагааг журмын дагуу зохион байгуулаагүй байна.	8-11
	2.1 <i>Зарим төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулаагүй байна.</i>	8-10
	2.2 <i>Гүйцэтгэгч байгууллага гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлсэн байна.</i>	11
ХАЯГ: Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 214 тоот	Бүлэг 3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлж дүгнэхгүй байна.	12-13
	3.1 <i>Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын тухайн жилд хүрэх зорилтот түвшинг тогтоож, үр дүнг тооцож ажиллаагүй байна.</i>	12
	3.2 <i>Нийт төсөл, арга хэмжээний 97.5 хувийг санхүүгийн тайланд тусгасан байна.</i>	12-13
	Дүгнэлт	14
	Зөвлөмж	14-15
	Шалгагдагч байгууллагын санал тайлбар	15
	Тайлан баталгаажуулсан тушаал	16-18
	Тайлангийн хавсралтууд	19-27
2018 оны 5 дугаар сар		

ТОВЧИЛСОН ҮГС

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ТББ	Төрийн бус байгууллага
АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар
ОНӨНҮҮГ	Орон нутгийн өмчит Нийтлэг үйлчилгээ үйлдвэрийн газар
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХАА	Худалдан авах ажиллагаа

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/06 дугаар тушаалаар батлагдсан аудитын сэдвийн төлөвлөгөө, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

“Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- ✓ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн үндэслэлтэй төлөвлөсөн эсэх;
- ✓ Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх;
- ✓ Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын өгөөжийг бодитой тооцож, үнэлсэн эсэх.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- ✓ Барилгын тухай хууль;
- ✓ Төсвийн тухай хууль;
- ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- ✓ Төрийн албаны тухай хууль;
- ✓ Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт;
- ✓ Дундговь аймгийн 2017 оны батлагдсан төсөв, түүнд орсон өөрчлөлтүүд;
- ✓ Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”;
- ✓ Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын журам”.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад орон нутгийн төсвөөс 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын 21 төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт болон эдгээр төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд, төсөл,

Аудитын арга зүй:

арга хэмжээг хэрэгжүүлэгчдийн үйл ажиллагааг хамруулав.

Аудитыг төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүй, тулгуур зарчим (АДБОУС 300), гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100)-ийг ашиглан, журам, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв. Аудитын арга зүйн дагуу холбогдох байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, худалдан авалт, хөрөнгө оруулалт болон санхүүгийн баримт материалыг түүвэрлэн шалгах, мэдээ тайланг гаргуулж тулган баталгаажуулах, зэрэгцүүлэх, харьцуулах, ажиглалт хийх, бодит байдлыг фото зураг авч баримтжуулах зэрэг шаардлагатай горимуудыг хэрэгжүүлэн, цуглуулсан нотлох баримтад харьцуулалт, судалгаа, шинжилгээ хийж дүнг нэгтгэн боловсруулж, түүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж өглөө.

**Аудит хийх багийн
бүрэлдэхүүн,
хугацаа:**


Аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг дарга, тэргүүлэх аудитор П.Төвсанаа хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал үе шатны чанарын хяналт хэрэгжүүлэн, гүйцэтгэлийн аудитын багийн ахлах аудитор Ч.Бэрхсайхан 2018 оны 2 дугаар сарын 26-ны өдрөөс 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдрийг дуустал хугацаанд гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл

Дундговь аймгийн ИТХ-ын 2016 оны 12 сарын 02-ны өдрийн “Аймгийн 2017 оны төсөв батлах тухай” 11 дүгээр тогтоолоор орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг батлаагүй. Харин 2017 оны 04 сарын 25-ны өдрийн “2017 оны орон нутгийн төсөвт өөрчлөлт оруулах тухай” 15 дугаар тогтоолоор 520.2 сая төгрөгийн 15 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, мөн 2017 оны 11 сарын 15-ны өдрийн “2017 оны орон нутгийн төсөвт өөрчлөлт оруулах тухай” 24 дүгээр тогтоолоор 615.4 сая төгрөгийн 22 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр өөрчлөн баталсан байна.

2017 онд 21 төсөл, арга хэмжээ хэрэгжиж 527.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

График 1



Тайлант онд нийт хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг бүтцээр нь авч үзвэл автомашин, сэлбэг хэрэгсэлд 201.8 сая төгрөг буюу 37%, барилгын засвар, тохижилтын ажилд 151.1 сая төгрөг буюу 28%, барилгын ажилд 69.9 сая төгрөг буюу 13%, сургалт сурталчилгаа зохион байгуулсан 22.4 сая төгрөг буюу 4%, бусад төсөл арга хэмжээнд 96.4 сая төгрөг буюу 18%-ийг зарцуулсан байна.

Бүлэг 1

• Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөхгүй байна.

1.1 зарим төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Засаг даргын мөрийн хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулаагүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 615.4 сая төгрөгийн 21 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсний 392.1 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ буюу 63.7 хувь нь Засаг даргын мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдаагүй, холбогдох байгууллагуудын саналыг үндэслэн ИТХ-аар хэлэлцүүлэн баталсан байна. /Хавсралт №1/

Энэ нь “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 3.1¹, 3.6² дахь заалтыг тус тус зөрчиж байна.

Тус асуудал нь аймгийн дунд хугацаанд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын бодлогогүй, төлөвлөлт, тооцоо судалгааг хангалттай хийдэггүй, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг авч эрэмбэлээгүй зэрэгтэй холбоотой байна.

Нийт төсөл арга хэмжээний 63.7% нь аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдаагүй байна.

Энэ нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт үр дүнгүй хэрэгжих, хэрэгцээ шаардлагатай асуудалд чиглэгдэхгүй байх үр дагаварыг бий болгож байна.

Иймд аймгийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, Засаг даргын мөрийн хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигтэй уялдуулан дунд хугацаанд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын бодлого боловсруулж, түүнд үндэслэн жил бүрийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг эрэмбэлэн төлөвлөж байх шаардлагатай байна.

¹ /Төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэл төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, тухайн санхүүгийн жилийн төсөлд тусгахдаа дараах зарчмыг баримтална. Үүнд:

-Салбарын хөгжлийн бодлого, салбарын болон бүс нутгийн дунд хугацааны стратеги, мастер төлөвлөгөөний зорилтыг хэрэгжүүлэх тэргүүлэх ач холбогдолтой хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ байх;

-Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэр бүхий орон нутагт хэрэгжүүлэх тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр, арга хэмжээ байх;/

² Төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг нийслэлийн тухайн санхүүгийн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь тухайн захиалагчийн дунд хугацаанд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй харилцан уялдсан байхын зэрэгцээ салбарын гол тэргүүлэх чиглэл, хөрөнгө оруулалтын ач холбогдол, тухайн төслийн хэрэгжилттэй уялдуулан эрэмбэлсэн байна.

1.2 Шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг баталсан байна.

Хийгдэх ажил, хүрэх үр дүн тодорхойгүй, тооцоо судалгаа хийгдээгүй 125.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээг “Хөтөлбөр, арга хэмжээ” нэрээр бөөн дүнгээр баталсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.16³, 4.1.17⁴, 29 дүгээр зүйлийн 29.2⁵, “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 3.4⁶ дэхь заалтыг тус тус зөрчсөн байна.



• **Бараа, ажил, үйлчилгээ гэрээний хугацаанд багтаж хэрэгжсэн боловч зарим худалдан авах ажиллагааг журмын дагуу зохион байгуулаагүй байна.**

2.1 Зарим төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулаагүй байна.

Хүснэгт 1 /сая төгрөг/

Нийт төсөл арга хэмжээ		Шууд худалдан авсан төсөл, арга хэмжээ		Харьцуулалтын арга хэрэглэсэн төсөл, арга хэмжээ				Тендер амжилтгүй болж гэрээ шууд байгуулсан төсөл, арга хэмжээ	
Тоо	Дүн	Тоо	Дүн	Амжилттай		Амжилтгүй		Тоо	Дүн
				Тоо	Дүн	Тоо	Дүн		
37	567.2	25	143.5	3	125.5	9	298.2	9	298.2

Шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарт багтсан 143.5 сая төгрөгийн 25 төсөл, арга хэмжээний

бараа, ажил, үйлчилгээг шууд худалдан авсан, харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас давсан төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээ байхгүй тул нээлттэй тендер шалгаруулалтын журам хэрэглээгүй харьцуулалтын арга хэрэглэсэн байна.

³ “хөтөлбөр” гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо уялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээг;

⁴ “арга хэмжээ” гэж хөтөлбөрийн бүрэлдэхүүнд багтах, тоо хэмжээ, цаг хугацаа, чанарын шалгуур зүүллэлтээр тодорхойлогдох ажил, үйлчилгээг; дэхь заалтыг тус тус зөрчсөн байна.

⁵ Хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байна.


⁶ Төсвийн хөрөнгөөр хийх их засварын ажлыг төлөвлөхдөө тухайн барилга байгууламжийн ашиглалт, норм, хугацаа, элэгдлийн байдал, мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, засварын хөрөнгийн төсөв, холбогдох материалыг үндэслэнэ.

Нийт 12 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд харьцуулалтын арга хэрэглэж 125.5 сая төгрөгийн 3 тендер амжилттай, 298.2 сая төгрөгийн 9 тендер амжилтгүй болж гэрээ шууд байгуулсан байна. /Хүснэгт 1/ /График 2/

Амжилтгүй болсон 9 тендерийг төсөл, арга хэмжээ бүрээр авч үзье. /Хүснэгт 2/

Хүснэгт 2 /сая төгрөг/

Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Урилга хүргүүлсэн эсэх
Модел хаус	69.9	Үгүй
Аймгийн ЗДТГ-ын автомашинуудын парк засвар	25.6	Үгүй
Аймгийн ЗДТГ-ын өрөө, танхимын их засварын ажил	38.1	Тийм
Орон нутгийн өмчийн байрны засварын ажил	12.4	Тийм
Цагдаагийн газрын албан хэрэгцээнд тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл	15.0	Тийм
Аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин	13.0	Үгүй
Аймгийн ЗДТГ-ын тоног, төхөөрөмж	15.9	Үгүй
Аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин	75.0	Үгүй
Аймгийн ЗДТГ-ын тохижилт	33.2	Үгүй



Тендер шалгаруулалт амжилтгүй болсон 9 төсөл, арга хэмжээний 6 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд үнийн санал ирүүлэх урилгыг 3 болон түүнээс дээш этгээдэд хүргүүлсэн албан бичиг, баримт байхгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2⁷, 33.2.1⁸-д заасныг тус тус зөрчиж байна.

Үнийн санал ирүүлэх урилгыг албан ёсоор хүргүүлээгүйгээс нэг ч этгээд тендер ирүүлээгүй тул тендер амжилтгүй болсон байна. /Хүснэгт 2/

Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулах, тендер шалгаруулалтын хавтаст хэргийг тухай бүр бүрдүүлж архивын нэгж болгон хадгалж байх талаар аймгийн Засаг даргад албан шаардлага хүргүүлсэн.

Аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин нийлүүлэх 75.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй нээлттэй тендер шалгаруулалтын журам хэрэглэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр харьцуулалтын арга хэрэглэн зохион байгуулсан.

⁷ /Харьцуулалтын аргыг дараахь байдлаар хэрэглэнэ:/

⁸ /Техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэх;/

Мөн “Аймгийн ЗДТГ-ын буудлын их засвар” төсөл, арга хэмжээний багц 2 буюу “Буудлын өрөөний тавилга” нийлүүлэх худалдан авах ажиллагааны төсөвт өртөг 21.8 сая төгрөг боловч 24.0 сая төгрөгөөр тендер зарласан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1⁹, 8.1.1¹⁰, мөн 8.2¹¹, 8.4¹², Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн босго үнэ шинэчлэн батлах тухай 68 дугаар тогтоолын хавсралтыг тус тус зөрчсөн байна.

Хүснэгт 3 /сая төгрөг/

Үнийн санал ирүүлсэн этгээд	Ирүүлсэн үнийн санал /сая төгрөг/
“Өнөмөнх хайрхан” ХХК	21.8
“Шувуутай оргил” ХХК	22.9
ОНӨНҮҮГ	22.0

“Буудлын өрөөний тавилга” нийлүүлэх тендерт 3 этгээд үнийн санал ирүүлсэн бөгөөд 24.0 сая төгрөгөөр тендер зарласан тул 21.8 сая төгрөгийн батлагдсан төсвөөс бага үнийн санал ирээгүй, 2

этгээд батлагдсан төсвөөс өндөр үнийн санал ирүүлсэн байна.

Энэ нь үнэлгээний хорооны ажилчдын хариуцлагагүй байдалтай холбоотой бөгөөд үүнээс шалтгаалан тендерийн хэмнэлт бий болох боломж алдах, тендерт оролцогч этгээдүүд батлагдсан төсвөөс хэтэрсэн үнийн санал ирүүлэх, тендерт оролцогч гомдол гаргах, тендер хүчингүй, амжилтгүй болох зэрэг үр дагавартай байна.

Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгон ажиллаж байх талаар аймгийн Засаг даргад хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

“Аймгийн ЗДТГ-ын автомашинуудын парк засвар”, “Орон нутгийн өмчийн байрны засвар”, “Аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин”, “Цагдаагийн газрын албан хэрэгцээнд тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл” нийлүүлэх ажлуудын худалдан авах ажиллагааны захиалагчаар аймгийн Засаг дарга ажилласан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2¹³, 45.2.2¹⁴ мөн 45.3¹⁵, 46 дугаар зүйлийн 46.1.3¹⁶ дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Худалдан авах ажиллагааны захиалагчаар аймгийн ЗДТГ-ыг ажиллуулж байх талаар аймгийн Засаг даргад хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

⁹ /Засгийн газар нь барааны, ажлын, үйлчилгээний гэсэн ангилал тус бүрээр дараахь босго үнийг тогтооно:/

¹⁰ /харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар;/

¹¹ /Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ./

¹² /Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно./

¹³ /Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад дор дурдсан этгээд захиалагч байна/

¹⁴ /аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь тухайн орон нутагт худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд/

¹⁵ /Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний хувьд тухайн шатны Засаг даргын Тамгын газар захиалагч байна./

¹⁶ /үнэлгээний хорооноос гаргасан дүгнэлтэд үндэслэн гэрээ байгуулах эрх олгох шийдвэр гаргах;/

2.2 Гүйцэтгэгч байгууллага гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлсэн байна.

Төсөл, арга хэмжээ нь гэрээнд заасан хугацаанд багтаж хэрэгжсэн боловч анх тендер зарлахад боловсруулсан техникийн тодорхойлолтоос зөрүүтэй бараа нийлүүлж, зарим ажлыг өөрчлөн гүйцэтгэсэн байна. /Хавсралт №3, Хүснэгт 4/.

Хүснэгт 4 /сая төгрөг/

Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Өөрчлөлт		
		Тендерийн техникийн тодорхойлолт		Нийлүүлсэн барааны үзүүлэлт
Аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин	13.0	Моторын хүчин чадал	1500	1490 cc
		Үйлдвэрлэгдсэн он	2006 оной хойш	2003 он
		Монголд ирсэн он	2016 оной хойш	2013 он
Аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин	75.0	Үйлдвэрлэгдсэн он	2006 оной хойш	2006 он
		Монголд ирсэн он	2016 оной хойш	2013 он
Аймгийн ЗДТГ-ын тоног, төхөөрөмж	33.2	Проектор, сандал, сандал	хүлээлгийн /3.3 сая төгрөг/	Сейф, Эйр кондейшн
Аймгийн ЗДТГ-ын тохижилт	15.9	Барилга засварын материал	/6.3 сая төгрөг/	Тавилга эд хогшил, тоног төхөөрөмж
Нийт	137.1			

Энэ нь Сангийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 4.21¹⁷ дэхь заалтыг зөрчиж байна.

Тус зөрчил нь нийлүүлэх барааны үзүүлэлт, техникийн тодорхойлолт, гүйцэтгэх ажлын төрөл, тоо хэмжээ зэргийг тооцоо судалгаагүй, төсөвт өртөгтэй нь уялдуулж төлөвлөөгүйдэй холбоотой байна.

Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн зардлыг хооронд нь шилжүүлэхгүй байх, батлагдсан нэр байршил, хүчин чадлыг өөрчлөхгүй байх талаар аймгийн Засаг даргад зөвлөмж хүргүүлээ.

¹⁷ Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэхийг хориглоно.



• Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлж дүгнэхгүй байна

3.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын тухайн жилд хүрэх зорилтот түвшинг тогтоож, үр дүнг тооцож ажиллаагүй байна.

Хүснэгт 5 /сая төгрөг/

Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Зарцуулсан
Аймгийн хүүхдийн 11-р чуулган	2.4	Хоол цайны зардал
Багийн Засаг дарга нарыг чадавхижуулах хөтөлбөр	1.8	Хоолны зардал, урлагийн тоглолтын билет
Цэргийн ангийн бүсийн сургалт	9.0	Хоол, буудал, шатахууны зардал
Бизнес эрхлэгч иргэдийг дэмжих хөтөлбөр	1.0	Хоолны зардал
Нийт	14.2	

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хоол цай, буудал, шатахуун зэрэг хөрөнгө оруулалтын бус нэг удаагийн шинж чанартай арга хэмжээнд 14.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. /Хүснэгт 6/

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24¹⁸ дэхь заалтыг зөрчсөн байна.

Цаашид орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хөрөнгө оруулалтын шинж чанартай, үр өгөөж бий болох төсөл, арга хэмжээ төлөвлөн, хэрэгжүүлж байх шаардлагатай байна.

Төсөл, арга хэмжээний хүрсэн үр дүн, тухайн жилийн зорилтот түвшний биелэлт болон бодит үр дүн гараагүй арга хэмжээ, түүний шалтгаан, цаашид авах арга хэмжээ зэргийг тооцож ажиллаагүй байна.

Иймд хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, төлөвлөгөөнд үндэслэн төсөл, арга хэмжээний жил бүрийн хүрэх үр дүнг тогтоож, хэрэгжилтийг тооцон цаашид авах арга хэмжээг тодорхойлж байх шаардлагатай байна.

3.2 Нийт төсөл, арга хэмжээний 97.5 хувийг санхүүгийн тайланд тусгасан байна.

Төсөл, арга хэмжээг санхүүгийн тайланд тусгахдаа 190.4 сая төгрөгийг шууд зардлаар, 43.6 сая төгрөгийг бараа материалын дансанд, 224.8 сая төгрөгийг үндсэн хөрөнгийн дансанд, 69.9 сая төгрөгийг авлагаар тус тус бүртгэж, 13.0 сая төгрөгийн ажлыг бүртгэлд тусгаагүй байна. /Хүснэгт 6, Хавсралт №4/

¹⁸ /"хөрөнгө оруулалт" гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;/

Хүснэгт 6 /сая төгрөг/

Дансны нэр	Дүн
Шууд зардал	190.3
Үндсэн хөрөнгө	224.7
Авлага	56.1
Бараа материал	43.5
Бүртгэлд тусгаагүй	13.0

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1¹⁹, 4.1.3²⁰, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт-17-н 27 дахь заалт, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.32²¹ дахь заалтыг тус тус зөрчиж байна.

Бүртгэлд тусгаагүй ажил, хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн санхүүгийн тайлан, тодруулгад бүртгэх талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

Мөн барилгын засварын ажлуудыг тухайн хөрөнгийг өмчлөгчийн санхүүгийн тайлан, тодруулгад бүртгээгүй, орон нутгийн хөрөнгө оруулалтын дансанд шууд зардлаар тайлагнасан байна.

Хүснэгт 7 /сая төгрөг/

Төсөл, арга хэмжээний нэр	Санхүүжилт	Хувийн хэрэг хөтөлсөн эсэх
Аймгийн ЗДТГ-ын өрөө, танхимын их засварын ажил	38.1	Үгүй
Орон нутгийн өмчийн байрны засварын ажил	12.4	Үгүй
Аймгийн ЗДТГ-ын буудлын их засвар	35.8	Үгүй
Дэлгэрхангай сумын ЗДТГ-ын засвар	9.6	Үгүй
Нийт	95.9	

Хүснэгт 7-д харуулсан 4 төсөл, арга хэмжээний 95.9 сая төгрөгийн барилгын засварын ажлыг барилгын хувийн хэрэгт нэмж хөтлөөгүй байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 33.1.18²², 46.1.2²³, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 180 дугаар тушаалаар батлагдсан барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журмын 1.3²⁴ дахь

заалтыг тус тус зөрчсөн байна.

Барилгын их засварын ажлыг барилгын хувийн хэрэгт нэмж хөтлөх талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

¹⁹ /Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө:/,

²⁰ /Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт./

²¹ /Барьж байгуулсан үндсэн хөрөнгийн өртөг нь барилгын материал, ажлын хөлс зэрэг холбогдох бүх зардлын дүнгээс бүрдэнэ./

²² /Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журмыг батлах:/,

²³ /энэ хуулийн 33.1.18-д заасан журмын дагуу барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх:/,

²⁴ /Барилга байгууламжийн хувийн хэрэг нь тухайн барилга байгууламжийн эдэлгээний хугацаанд хийгдсэн өргөтгөл, өөрчлөлт, шинэчлэл, их засварын ажил, үзлэг шалгалт, гарсан эвдрэл, гэмтэл, согогын талаарх мэдээлэл, уг барилга байгууламжийн үндсэн үзүүлэлтийг агуулсан баримт бичиг байна./

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөхгүй байна.

- Зарим төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Засаг даргын мөрийн хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулаагүй байна.
- Шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ баталсан байна.

Бараа, ажил, үйлчилгээ гэрээний хугацаанд багтаж хэрэгжсэн боловч зарим худалдан авах ажиллагааг журмын дагуу зохион байгуулаагүй байна.

- Зарим төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулаагүй байна.
- Гүйцэтгэгч байгууллага гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлж дүгнэхгүй байна.

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын тухайн жилд хүрэх зорилтот түвшинг тогтоож, үр дүнг тооцож ажиллаагүй байна.
- Нийт төсөл, арга хэмжээний 97.5 хувийг санхүүгийн тайланд тусгасан байна..

Зөвлөмж

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг дарга-д:

1. Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, Засаг даргын мөрийн хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигтэй уялдуулан дунд хугацаанд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын бодлого боловсруулж түүнд үндэслэн жил бүрийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг эрэмбэлэн төлөвлөж байх.
2. Хөрөнгө оруулалтын шинж чанартай, ирээдүйд үр өгөөж бий болох хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлж байх.
3. Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн зардлыг хооронд нь шилжүүлэхгүй байх, батлагдсан нэр байршил, хүчин чадлыг өөрчлөхгүй байх.

4. Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого төлөвлөгөөг үндэслэн жил бүрийн хүрэх үр дүнг тогтоож, хэрэгжилтийг тооцон, цаашид авах арга хэмжээг тодорхойлж байх.

Шалгагдагч байгууллагын санал тайлбар



ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

48090 Сайнцагаан сум, Дундговь аймаг,
Утас: 7059-2494, Факс: 7059-2896,
E-mail: info@dundgovi.gov.mn

2018.05.16 № 4/374
танай _____ -ны № _____ -т

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Хүргүүлэх санал тайлбар байхгүй болно.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА ~~А.Эрдэнэ-Очир~~ Н.ЭРДЭНЭ-ОЧИР



П. Төрхсэмбаяр
Аудитын газар ашиглах

0300641

D:\Албан бичиг\2018 ТДА5.docx

Тайлан баталгаажуулсан тушаал



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2018 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/9

Мандалговь

Г Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 121 дүгээр тушаал, Гүйцэтгэлийн аудитын журмын 12 дугаар зүйлийн 12.40, Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журмын 4.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан /ГАГ-ДУА-2018-01-ГА/-г баталсугай.

2. Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт (албан шаардлага, зөвлөмж)-ыг хавсралтаар баталсугай.

3. “Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

4. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгаж, албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар 2018 оны 10 дугаар сарын 23-ны дотор аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн Засаг дарга /О.Бат-Эрдэнэ/-д зөвлөсүгэй.

5. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2018 оны 4 дүгээр улиралд гарган танилцуулахыг аудитын менежер /Х.Наранцацрал/, гүйцэтгэлийн аудитын албаны ахлах аудитор /Ч.Бэрхсайхан/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР П.ТӨВСАНАА





Аудитаар илрүүлсэн зөрчлийн жагсаалт

Аудитын код: ГАГ-ДУА-2018-01-ГА

Аудитын нэр: "Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг"

№	Зөрчлийн товч утга	Зөрчигдсэн хуулийн заалт	Зөрчлийн дүн сая төг	Үүнээс		Үр өгөөжийн			
				Аудитын явцад барагдуулсан	Алг тавигдсан	Албан шаардлага өгсөн	Зөвлөмжөөр өгсөн	Тоо	Мөнгөн дүн
1	Барилгын хувийн хэрэгт засварын ажлыг нэмж хөтлөөгүй, санхүүгийн тайланд тусгаагүй (Дэлгэрхангай)	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1 4.1.3, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 4.32	9.6			9.6		1	9.6
2	Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хэрэгцээнд автомашин нийлүүлэх 75,000,000.00 /Далан таван сая/ төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 50,000,000.00 /Тавин сая/ төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр харьцуулалтын арга хэрэглэн зохион байгуулсан байна "Аймгийн ЗДТГ-ын буудлын их засвар" төсөл, арга хэмжээний багц 2 буюу "Буудлын өрөөний тавилга" нийлүүлэх худалдан авах ажиллагааны төсөвт өртөг 21.8 сая төгрөг боловч 24.0 сая төгрөгөөр тендер зарласан	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.1.1, 8.2, 8.4	25.0			25.0		1	25.0
3	Худалдан авах ажиллагааны баримтын бүрдэл дутуу архивын нэгж үүсгэсэн. Мөн Модөл хаус, АЗДТГ-ын автомашины парк засвар, АЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин, АЗДТГ-ын тоног төхөөрөмж, АЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин нийлүүлэх тендерийн үнийн санал ирүүлэхийг 3 болон түүнээс дээш этгээдэд мэдэгдсэн албан бичиг, баримт байхгүй	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 49.2, 33.2, 33.2.1	-			-		1	-
4	Засаг даргын Тамгын газрын барилгын их засварын ажил, буудлын их засварын ажлыг хувийн хэрэгт нэмж хөтлөөгүй	Барилгын тухай хуулийн 33.1.18, 46.1.2, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 180 дугаар тушаалаар батлагдсан барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журмын 1.3	107.2			107.2		1	107.2
5	"Аймгийн ЗДТГ-ын автомашины парк засвар", "Орон нутгийн өмчийн байрны засвар", "Аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин", "Цагдаагийн газрын албан хэрэгцээнд тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл" нийлүүлэх ажлуудын худалдан авах ажиллагааны захиалагчаар аймгийн Засаг дарга ажилласан	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2, 45.2.2, 45.3, 46.1.3	-			-		1	-
6	"Ухаан далай номоос ихтэй" төслөөр хэрэгжсэн ажлыг санхүүгийн тайланд тайлагнаагүй.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.1.3, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт-17-н 27 дахь заалт, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 4.32	3.0			3.0		1	3.0

7	Аймгийн дунд хугацаанд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын бодлогогүй, төлөвлөлт, тооцоо судалгааг хангалттай хийдэггүй, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг авч эрэмбэлээгүй	"Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам"-ын 3.1, 3.6	-					1	-
8	Хийгдэх ажил, хүрэх үр дүн тодорхойгүй, тооцоо судалгаа хийгдээгүй, төсөл, арга хэмжээг "Хөтөлбөр, арга хэмжээ" нэрээр бөөн дүнгээр баталсан	Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам"-ын 3.4	125.8				125.8	1	125.8
9	Нийлүүлэх барааны үзүүлэлт, техникийн тодорхойлолт, гүйцэтгэх ажлын төрөл, тоо хэмжээ зэргийг тооцоо судалгаагүй, төсөвт өртөгтэй нь уялдуулж төлөвлөөгүй	Сангийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам"-ын 4.21	-					1	-
10	Төсөл, арга хэмжээний хүрсэн үр дүн, тухайн жилийн зорилтот түвшний биелэлт болон бодит үр дүн гараагүй арга хэмжээ, түүний шалтгаан, цаашид авах арга хэмжээ зэргийг тооцож ажиллаагүй	Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24	-					1	-
Дүн			270.6	-	-	144.9	125.8	10	270.6

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар

ТАЙЛАН БИЧСЭН:

**АХЛАХ АУДИТОР
АУДИТОР**

**Ч.БЭРХСАЙХАН
Р.ХАШ-ЭРДЭНЭ**

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.НАРАНЦАЦРАЛ



Тайлангийн хавсралт

Хавсралт №1

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ болон эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн уялдаа

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Нийгэм эдийн засгийн үндсэн чиглэлийн заалт	Засаг даргын мөрийн хөтөлбөрийн заалт	Тайлбар
1	Модел хаус			Аймгийн ИТХ-ын дарга асуудал тавьж Аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн баталсан.
2	Автомашины парк засвар /аймгийн ИТХ/			Аймгийн ИТХ санал тавьж аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн баталсан.
3	Автомашины парк засвар /Эрдэнэдалай/			Эрдэнэдалай сумын ЗДТГ санал ирүүлэн Аймгийн ИТХ-аар батлагдсан.
4	Автомашины парк засвар, /аймгийн Ахмадын хороо/			Аймгийн Ахмадын хороо санал тавьж аймгийн ИТХ-аар батлуулан хийсэн.
5	Автомашины парк засвар, /Эрдэнэдалай ИТХ/			Эрдэнэдалай сумын ИТХ санал ирүүлэн аймгийн ИТХ-аар баталсан.
6	Аймгийн ЗДТГ-ын автомашинуудын парк засвар			Аймгийн ЗДТГ санал ирүүлж аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн баталсан.
7	Аймгийн ЗДТГ-ын буудлын их засвар	6.1.11		
8	Аймгийн ЗДТГ-ын өрөө, танхимын их засварын ажил			Аймгийн ЗДТГ санал ирүүлж аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн баталсан.
9	Орон нутгийн өмчийн байрны засварын ажил			Аймгийн ЗДТГ санал ирүүлж аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн баталсан.
10	Дэлгэрхангай сумын ЗДТГ-ын засвар		6.2.6	
11	Сумдын ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин /Дэрэн/			Дэрэн сумын ЗДТГ санал ирүүлэн аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн баталсан.

12	Аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин			Аймгийн ЗДТГ санал ирүүлж аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн баталсан.
13	Эмнэлгийн барилгуудыг генератортой холбоход шаардлагатай цахилгааны утас	3.1.8	3.1.3	
14	5 сумын хэсгийн төлөөлөгч, цагдаагийн мотоцикл	6.1.17	1.3.6	
15	Эмнэлгийн ариутгалын автоклавны манометр шалган баталгаажуулах эталон төхөөрөмж	1.2.10	3.1.5 3.1.8	
16	10 багийн Засаг даргыг унаажуулах	6.1.17	1.1.6	
17	Аймгийн ЗДТГ-ын тохижилт			Аймгийн ЗДТГ санал ирүүлж аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн баталсан.
18	Аймгийн ЗДТГ-ын тоног, төхөөрөмж			Аймгийн ЗДТГ санал ирүүлж аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн баталсан.
20	Цагдаагийн газрын албан хэрэгцээнд тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл		1.3.6	
2. Хөтөлбөр арга хэмжээ				
21	Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийг цахимжуулах хөтөлбөр	1.2.8	1.2.7	
22	"Аялал жуулчлалыг хөгжүүлэх" хөтөлбөр	5.2.2	5.2.1 5.2.2	.
23	Аймгийн "Хүүхдийн 11-р чуулган"	3.5.6	3.5.3	
24	Багийн Засаг дарга нарыг чадавхижуулах хөтөлбөр	1.2.2	1.2.3	
25	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги, хөтөлбөр	1.3.2	6.2.12 6.2.16	
26	Аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд тоног төхөөрөмж нийлүүлэх, тохижилтын ажил			Аймгийн ЗДТГ санал ирүүлж аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн баталсан.
27	Төрийн байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааг ТББ-аар үнэлүүлэх	4.2.5	1.1.10	
28	Бизнес эрхлэгч иргэдийг дэмжих хөтөлбөр	2.1.3	2.1.4 2.1.5	
29	"И-оффис" хөтөлбөр			Аймгийн ЗДТГ, "Эйбл Софт" ХХК-тай байгуулсан гэрээний дагуу "И-оффис" хөтөлбөр хэрэгжүүлж Эйбл системийг ашиглаж байна.
30	"Архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах" төсөл	1.1.5	1.2.5 1.2.6	

31	Өсвөрийн шигшээ багийг тоглолтын хувцасаар хангах	3.3.1	3.1.4 3.1.5	
32	Сүм хөх бүрдийн тохижилт	5.2.2	5.2.6	
33	Авилгатай тэмцэх хөтөлбөр /11/	1.2.5	1.2.4	
34	Эрх зүйн сургалт сурталчилгаа /12/	1.2.2	1.2.2, 1.2.3	
35	Цэргийн ангийн бүсийн сургалт /13/			Аймгийн ИТХ-аар баталсан хөтөлбөр арга хэмжээний зардлаас санхүүжигдэн Говийн бүсийн аймаг, сумын ЗДТГ-ын дарга нарын "Цэргийн бэлтгэл" сургалтын төсөл хэрэгжсэн.
36	Ухаан далай номоос эхтэй төсөл /14/	3.4.10	3.4.15 3.4.16	
37	"И-оффис" хөтөлбөр			Аймгийн ЗДТГ,"Эйбл Софт" ХХК-тай байгуулсан гэрээний дагуу "И-оффис" хөтөлбөр хэрэгжүүлж Эйбл системийг ашиглаж байна.

ТЕНДЕРИЙН ХУГАЦАА

Д/д	Төсөл арга хэмжээний нэр	Тендерийн урилга хүргүүлсэн хугацаа	Тендер хүлээн авах эцсийн хугацаа	Тендер нээсэн хугацаа	Эрх олгосон огноо	Гэрээ байгуулсан огноо	Тендер үргэлжилсэн хугацаа
1	Модел хаус	Урилга хүргүүлсэн баримт байхгүй	2017.07.06-ны 10:00 цаг	2017.07.06-ны 10:30 цаг	Тендер амжилтгүй болсон	2017.07.26	
2	Аймгийн ЗДТГ-ын автомашинуудын парк засвар	Урилга хүргүүлсэн баримт байхгүй	2017.12.15-ны 10:00 цаг	2017.12.15-ны 10:30 цаг	Тендер амжилтгүй болсон	2017.12.18	
3	Аймгийн ЗДТГ-ын буудлын их засвар	2017.04.12	2017.04.18-ны 10:00 цаг	2017.04.18-ны 10:30 цаг	2017.04.25	2017.05.08, 2017.05.08	20 хоног
4	Аймгийн ЗДТГ-ын өрөө, танхимын их засварын ажил	2017.06.28	2017.07.06-ны 13:00 цаг	2017.07.06-ны 13:30 цаг	Тендер амжилтгүй болсон	2017.07.31	
5	Орон нутгийн өмчийн байрны засварын ажил	2017.10.12	2017.10.20-ний 09:30 цаг	2017.10.20-ний 10:00 цаг	Тендер амжилтгүй болсон	2017.11.17	
6	Сумдын ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин /Дэрэн/	Урилга хүргүүлсэн баримт байхгүй	2017.05.26-ны 10:00 цаг	2017.05.26-ны 10:10 цаг	2017.05.29	2017.06.07	12 хоног
7	Аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин	Урилга хүргүүлсэн баримт байхгүй	2017.05.26-ны 10:00 цаг	2017.05.26-ны 10:30 цаг	Тендер амжилтгүй болсон	2017.06.29	
8	10 багийн Засаг даргыг унаажуулах	2017.05.12	2017.05.22-ний 10:00 цаг	2017.05.22-ний 11:00 цаг	2017.06.08	2017.06.20	29 хоног
9	Аймгийн ЗДТГ-ын тохижилт	2017.06.22	2017.06.29-ний 10:00 цаг	2017.06.29-ний 10:30 цаг	Тендер амжилтгүй болсон	2017.07.31	
10	Аймгийн ЗДТГ-ын тоног, төхөөрөмж	Урилга хүргүүлсэн баримт байхгүй	2017.06.27-ны 15:00 цаг	2017.06.27-ны 15:30 цаг	Тендер амжилтгүй болсон	2017.07.05	
11	Аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин	Урилга хүргүүлсэн баримт байхгүй	2017.12.19-ний 10:00 цаг	2017.12.19-ны 10:30 цаг	Тендер амжилтгүй болсон	2017.12.20	

12	Цагдаагийн газрын албан хэрэгцээнд тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл	2017.12.01	2017.12.11-ний 10:00 цаг	2017.12.11-ний 10:30 цаг	Тендер амжилтгүй болсон	2017.12.18	
----	---	------------	--------------------------	--------------------------	-------------------------	------------	--

Хавсралт №3

Тендер шалгаруулалтын хавтаст хэрэгт бүрдүүлэх материал

Д/Д	Төсөл арга хэмжээний нэр	ХАА-ны төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлбар	Бараа, ажил үйлчилгээний тодорхойлолт, тендерийн баримт бичиг	Тендер оролцогчтой харилцсан албан бичиг	Тендер оролцогчдын ирүүлсэн тендер	Тендерийн нээлтийн тэмдэглэл	Үнэлгэний хорооны дүгнэлт	Гэрээ байгуулах эрх олгосон зөвлөмж	Тендер шалгаруулалт амжилтгүй болсон, татгалзсан шалтгаан, үндэслэл	Тендерийг хянан үзэх	Техникийн тодорхойлолт	Тендерийн урилга хүргүүлсэн баримт	Гэрээ байгуулах эрх олгох шийдвэр, гэрээ	Гэрээг дүгнэж, бараа, ажил үйлчилгээг хүлээж авсан баримт бичиг
1	Модел хаус	байна	байна			2017.07.06-ны хурлын тэмдэглэл	байна	байна	тендерт материал ирээгүй		байна	байхгүй	байна	Гэрээний хугацаа сунгагдаж он дамжин хэрэгжиж байгаа
2	Аймгийн ЗДТГ-ын автомашинуудын парк засвар	байна	байна			2017.12.15-ны хурлын тэмдэглэл			тендерт материал ирээгүй		байна	байхгүй	байна	байна
3	Аймгийн ЗДТГ-ын буудлын их засвар	байна	байна	байна	байна	байна	байна	байна	амжилттай	байна	байна	байна	байна	байна
4	Аймгийн ЗДТГ-ын өрөө, танхимын их засварын ажил	байна	байна			байна	байна	байна	тендерт материал ирээгүй		байна	байна	байна	байна

5	Орон нутгийн өмчийн байрны засварын ажил	байна	байна	байхгүй	байна	байна	байна	байна	тендер ирүүлсэн оролцогч шаардлага хангаагүй	байна	байна	байна	байна	байна
6	Сумдын ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин /Дэрэн/	байна	байхгүй		байна	байна	байна	байна	амжилттай	байна	байхгүй	байхгүй	байхгүй	байхгүй
7	Аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин	байна	байна			2017.06.06-ны хурлын тэмдэглэл	байна		тендерт материал ирээгүй		байна	байхгүй	байна	байна
8	10 багийн Засаг даргыг унаажуулах	байна	байна	байна	байна	байна	байна	байна	амжилтай	байна	байна	байна	байна	байна
9	Аймгийн ЗДТГ-ын тохижилт	байна	байна			2017.06.29-ны хурлын тэмдэглэл	байна	байна	тендерт материал ирээгүй		байна	байна	байна	байна
10	Аймгийн ЗДТГ-ын тоног, төхөөрөмж	байна	байна			2017.06.27-ны хурлын тэмдэглэл	байна	байна	тендерт материал ирээгүй		байна	байхгүй	байна	байна
11	Аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин	байна	байна	байна			байна	байна	тендерт материал ирээгүй		байна	байхгүй	байна	байна
12	Цагдаагийн газрын албан хэрэгцээнд тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл	байна	байна			2017.12.11-ний хурлын тэмдэглэл	байна		тендерт материал ирээгүй		байна	байна		байна

Төсөл, арга хэмжээг санхүүгийн тайланд тусгасан байдал

Д/д	Төсөл арга хэмжээний нэр	Санхүүжилт авсан гүйцэтгэлийн дүн	Байгууллагын нэр	/сая төгрөгөөр/	
				Бүртгэлийн данс	Бүртгэлийн дүн
1	Модел хаус	56.1	Хүлээж аваагүй байгаа	Авлагаар тусгасан	56.1
2	Автомашин парк засвар /аймгийн ИТХ/	10.0	Аймгийн ИТХ	Шууд зардлаар бүртгэсэн	10.0
3	Автомашин парк засвар /Эрдэнэдалай/	10.0	ОНХО	Шууд зардлаар бүртгэсэн	10.0
4	Автомашин парк засвар, /аймгийн Ахмадын хороо/	1.0	ОНХО	Шууд зардлаар бүртгэсэн	1.0
5	Автомашин парк засвар, /Эрдэнэдалай ИТХ/	3.7	ОНХО	Шууд зардлаар бүртгэсэн	3.7
6	Аймгийн ЗДТГ-ын автомашинуудын парк засвар	25.6	ОНХО	Шууд зардлаар бүртгэсэн	25.6
7	Аймгийн ЗДТГ-ын буудлын их засвар	57.6	1. ОНХО ОНӨНҮҮГ	2. 1. Шууд зардлаар бүртгэсэн 2. Тавилга эд хогшил	1. 35.9 2. 21.7
8	Аймгийн ЗДТГ-ын өрөө, танхимын их засварын ажил	38.1	ОНХО	Шууд зардлаар бүртгэсэн	38.1
9	Орон нутгийн өмчийн байрны засварын ажил	12.5	ОНХО	Шууд зардлаар бүртгэсэн	12.5
10	Дэлгэрхангай сумын ЗДТГ-ын засвар	9.6	ОНХО	Шууд зардлаар бүртгэсэн	9.6
11	Сумдын ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин /Дэрэн/	49.9	ЗДТГ /Дэрэн/	Тээврийн хэрэгсэл	49.9
12	Аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин	13.0	Аймгийн ЗДТГ	Тээврийн хэрэгсэл	13.0
13	Эмнэлгийн барилгуудыг генератортой холбоход шаардлагатай цахилгааны утас	9.6	Нэгдсэн эмнэлэг	Барилгын засварын материал	9.6
14	5 сумын хэсгийн төлөөлөгч, цагдаагийн мотоцикл	10.0	Цагдаагийн газар	Тээврийн хэрэгсэл	10.0

15	Эмнэлгийн ариутгалын автоклавны манометр шалган баталгаажуулах эталон төхөөрөмж	9.0	Стандарт хэмжилзүйн хэлтэс	Машин тоног төхөөрөмж	9.0
16	10 багийн Засаг даргыг унаажуулах	17.8	Адаацаг, Дэрэн, Луус, Өлзийт, Хулд, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Дэлгэрцогт, Сайнцагаан-2 ЗДТГазар	Тээврийн хэрэгсэл	17.8
17	Аймгийн ЗДТГ-ын тохижилт	33.2	Аймгийн ЗДТГ	1.Аж ахуйн материал 2. Машин тоног төхөөрөмж 3. Тавилга эд хогшил	1. 1.5 2. 3.7 3. 27.9
18	Аймгийн ЗДТГ-ын тоног, төхөөрөмж	15.9	Аймгийн ЗДТГ	1.Аж ахуйн материал 2. Машин тоног төхөөрөмж 3. Тавилга эд хогшил	1. 3.7 2. 9.6 3. 2.5
19	Аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд автомашин	49.5	Аймгийн ЗДТГ	Тээврийн хэрэгсэл	49.5
20	Цагдаагийн газрын албан хэрэгцээнд тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл	15.0	Цагдаагийн газар	Сэлбэг хэрэгсэл	15.0
21	Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийг цахимжуулах хөтөлбөр	10.0	Улсын бүртгэлийн хэлтэс	Бүртгэлд тусгаагүй. Төрийн өмчийн хороонд бүртгэлд авах тухай саналаа явуулсан.	
22	"Аялал жуулчлалыг хөгжүүлэх" хөтөлбөр	2.2	ОНХО	Шууд зардлаар бүртгэсэн	2.2
23	Аймгийн "Хүүхдийн 11-р чуулган"	2.4	ОНХО	Шууд зардлаар бүртгэсэн	2.4
24	Багийн Засаг дарга нарыг чадавхижуулах хөтөлбөр	1.8	ОНХО	Шууд зардлаар бүртгэсэн	1.8
25	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги, хөтөлбөр	10.0	Цагдаагийн газар	Машин тоног төхөөрөмж	9.9

26	Аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд тоног төхөөрөмж нийлүүлэх, тохижилтын ажил	7.5	ОНХО	Шууд зардлаар бүртгэсэн	7.5
27	Төрийн байгууллагуудын 2017 оны үйл ажиллагааг ТББ-аар үнэлүүлэх	0.7	ОНХО	Шууд зардлаар бүртгэсэн	0.7
28	Бизнес эрхлэгч иргэдийг дэмжих хөтөлбөр	1.0	ОНХО	Шууд зардлаар бүртгэсэн	1.0
29	"И-офисс" хөтөлбөр	5.6	ОНХО	Шууд зардлаар бүртгэсэн	5.6
30	"Архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцлийг сайжруулах" төсөл	2.1	ОНХО	Шууд зардлаар бүртгэсэн	2.1
31	Өсвөрийн шигшээ багийг тоглолтын хувцасаар хангах	6.2	Биеийн тамир, спортын газар	Аж ахуйн материал	6.2
32	Сүм хөх бүрдийн тохижилт	7.4	ОНӨНҮҮГазар	Аж ахуйн материал	7.4
33	Авилгатай тэмцэх хөтөлбөр /11/	3.0	ОНХО	Шууд зардлаар бүртгэсэн	3.0
34	Эрх зүйн сургалт сурталчилгаа /12/	3.0	ОНХО	Шууд зардлаар бүртгэсэн	3.0
35	Цэргийн ангийн бүсийн сургалт /13/	9.0	ОНХО	Шууд зардлаар бүртгэсэн	9.0
36	Ухаан далай номоос эхтэй төсөл /14/	3.0	Номын сан	Бүртгэлд тусгаагүй	
37	"И-офисс" хөтөлбөр	5.6	ОНХО	Шууд зардлаар бүртгэсэн	5.6
НИЙТ		527.8			514.8